



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/114

Баянтал сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 121 дүгээр тогтоолын 2-дугаар хавсралт " Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.7, 4.9 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боржигин овогтой Сэнгийн Оюунчимэг (РД:ЕЙ59080705) нь Лүн баг 621-р зөрлөгийн блокон хашааны хойд талд байрлах худалдаа үйлчилгээний зориулалттай 1200м² газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул Даржаа овогтой Баасансүрэнгийн Энхсайхан (РД:Г382051300) -д дээрхи газрыг анх авсан газар эзэмшигчийн үлдсэн 3 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу эзэмшилдээ авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг иргэн (Б.Энхсайхан)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэж, хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, газрыг улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Батчимэг)-д зөвшөөрсүгэй.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны А/106 дугаар захирамжны холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/13

Баянтал сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2, Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 121 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт " Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Иргэн Халхай овогт Лхамын Банди /РД: ЗМ54011716/ нь Лүн багт Тэрэгтийн дунд байршилтай 4203001929 нэгж талбарын дугаартай 700м² өвөлжөөний зориулалттай газрынхаа газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тул 20 жилийн хугацаатайгаар сунган эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг газар эзэмшигч (Л.Банди)-д үүрэг болгосугай.


3.Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй газар эзэмшигч (Л.Банди)-тэй эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудас болон газар эзэмших гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Батчимэг)-д зөвшөөрсүгэй.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2010 оны А/150 дугаар захирамжны холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА



جمهوری اسلامی ایران
کمیسیون عالی قضایی
کمیسیون عالی قضایی

وکیل پایه یک دادگستری

کمیسیون عالی قضایی


کمیسیون عالی قضایی

تأیید صلاحیت وکیل پایه یک دادگستری
کمیسیون عالی قضایی

این تأییدیه به موجب این سند صادر می‌گردد و اعتبار آن از تاریخ صدور تا تاریخ ۱۳۹۰/۰۱/۰۱ می‌باشد. این تأییدیه صرفاً جهت احراز صلاحیت وکیل پایه یک دادگستری جهت شرکت در آزمون وکیل پایه یک دادگستری می‌باشد. این تأییدیه فاقد هرگونه ضمانت است و مسئولیت هرگونه اقدام غیرقانونی یا تخلف از مقررات مربوطه بر عهده متقاضی است.

این تأییدیه به موجب این سند صادر می‌گردد و اعتبار آن از تاریخ صدور تا تاریخ ۱۳۹۰/۰۱/۰۱ می‌باشد. این تأییدیه صرفاً جهت احراز صلاحیت وکیل پایه یک دادگستری جهت شرکت در آزمون وکیل پایه یک دادگستری می‌باشد. این تأییدیه فاقد هرگونه ضمانت است و مسئولیت هرگونه اقدام غیرقانونی یا تخلف از مقررات مربوطه بر عهده متقاضی است.

این تأییدیه به موجب این سند صادر می‌گردد و اعتبار آن از تاریخ صدور تا تاریخ ۱۳۹۰/۰۱/۰۱ می‌باشد. این تأییدیه صرفاً جهت احراز صلاحیت وکیل پایه یک دادگستری جهت شرکت در آزمون وکیل پایه یک دادگستری می‌باشد. این تأییدیه فاقد هرگونه ضمانت است و مسئولیت هرگونه اقدام غیرقانونی یا تخلف از مقررات مربوطه بر عهده متقاضی است.



کمیسیون عالی قضایی

کمیسیون عالی قضایی

4292600017



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/112

Баянтал сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2, Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 121 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Анхалдай овогт Сэржээгийн Басан /РД:ХЖ57111118/ нь Лүн багт Цэргийн ангийн торны зүүн талд байрлах 4203002175 нэгж талбарын дугаартай 700м² хаваржааны зориулалттай газрынхаа газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тул 20 жилийн хугацаатайгаар сунган эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг газар эзэмшигч (С.Басан)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй газар эзэмшигч (С.Басан)-тэй эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудас болон газар эзэмших гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Батчимэг)-д зөвшөөрсүгэй.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2010 оны А/150 дугаар захирамжны холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА

4212600016



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/11

Баянтал сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2, Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 121 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт " Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Баяуд-овогт Пүрэвдорж Төмөрбаатар /РД: ТГ62012010/ нь Лүн багт Босгоны арын кавинтайд байршилтай 4203002172 нэгж талбарын дугаартай 700м² хаваржааны зориулалттай газрынхаа газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тул 20 жилийн хугацаатайгаар сунган эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг газар эзэмшигч (П.Төмөрбаатар)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй газар эзэмшигч (П.Төмөрбаатар)-тэй эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудас болон газар эзэмших гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Батчимэг)-д зөвшөөрсүгэй.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны А/53 дугаар захирамжны холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



ЗАСАГ ДАРГА

Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/10

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Сумын 2026 оны төсөвт батлах” тухай 03 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит 01 дүгээр хуралдаанаар хэлэлцэж баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн “Гамшгаас хамгаалах зардал” арга хэмжээний шатахууны зардлаас 1,981,800 (нэг сая есөн зуун наян нэгэн мянга найман зуу) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх хөрөнгийг 2026 оны сумын төсөвт тусгагдсаны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн зардлаас санхүүжүүлэхийг санхүү албаны ерөнхий нягтлан бодогч (Б.Солонгомаа)-д даалгасугай

3.Захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болсугай.

ЗАСАГ ДАРГА



Э. БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/09

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1,23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын зөвлөлийн 2026 оны 02 дугаар ээлжийн хуралдаанаар хэлэлцэгдэж, дэмжигдсэн арга хэмжээнүүдэд 3,582,500 (гурван сая таван зуун наян хоёр мянга таван зуу) төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 3,582,500 (гурван сая таван зуун наян хоёр мянга таван зуу) төгрөгийг Сумын Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын дарга (Ш.Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

4212600003



Засаг даргын 2026 оны 02 дугаар
Сумын захирлын нийгэмдрийн А/ тоот
захирамжийн хавсралт

№	Арга хэмжээ	Тоо ширхэг	Төсөв	Нийт
1	Сумын аварга малчин / үнэ бүхий дурсгалын зүйлс/	2	700,000	1,400,000
2	Сумын алдарт уяач /цол тэмдэг, үнэ бүхий дурсгалын зүйлс	3	700,000	2,100,000
3	Сумын мянгат малчин	1	82,500	82,500
Нийт дүн			3,582,500	



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/08

Баянтал сум

Ажил хүлээн авах комисс томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжүүлэх журам”-ын 4.13 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2026 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн “Он дамжсан 2025 оны зураг төсвийн ажлууд”-ыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:

Э.Эрхэмбаатар (Засаг даргын орлогч)

Гишүүд:

Н.Баярмаа (ИТХ-ын төлөөлөгч)

М.Амаржаргал (“Талын Илч” ОНӨААТҮГ-ын
ХАЭБ, инженер)

Н.Сарантуяа (ЗДТГ-ын аж ахуй нярав)


Нарийн бичгийн дарга:

М.Бодьгэрэл (Нийгмийн бодлого, худалдан
авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичиг, гэрээнд заасны дагуу ажлын тоо хэмжээг тулган үзэж, чанартай гүйцэтгүүлж, хүлээн авахыг ажлын хэсгийн комиссын гишүүдэд даалгасугай.

3.“Он дамжсан 2025 оны зураг төсвүүд” хийх шууд худалдан авалтын тендерийн ажлыг комиссын зөвлөмжид дүгнэлтийг үндэслэн, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаж, эзэмшил ашиглалтад хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА

D:/My Documents/2026 ajil/zahiramj.doc

4212600031



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/107

Баянтал сум

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга
хэмжээнээс орж ирсэн орлогыг
зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам” -ын 2 дугаар тогтоолын 3 дугаар зүйл 3.1, 3.4, 3.5, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулах төсвийн задаргааг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний орлого 21,113,100 (Хорин нэгэн сая нэг зуун арван гурван мянга нэг зуун) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулахыг Санхүү албаны ерөнхий нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.

3.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Ш.Шинэбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА

Засаг даргын 2026 оны 02 дугаар сарын 03 нийгэдрийн А/07 тоот захирамжийн хавсралт



Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулах төсвийн задаргаа

/Мянган төгрөгөөр/

№	Төсөл арга хэмжээний нэр	Зарцуулах төсөв
1. Хөтөлбөр төсөл, арга хэмжээ		
1.1	"Тэрбум мод үндэсний хөдөлгөөний" хүрээнд сумын хэмжээнд нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх /мод, бут/	7,740.0
1.2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний үлдэгдэл төлбөр	2,700.0
1.3	Геодизын хатуу цэг тэмдэг сэргээх /4 цэг/	10,673.1
Нийт дүн		21,113.1